


# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


Сарын тойм: 2016 оны 2 дугаар сар

## МХБ-ийн индексүүд

**Топ-20 индекс, 11,545.71 -15.71%** (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



**MSE ALL индекс, 838.64 -10.48%** (индексийн анхны өдөртэй харьцуулсан өөрчлөлт)



## МХБ-ийн Топ-20 хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэр	Санал	7/Ш	Өөрчлөлт
Таван толгой ХК (TTL)	Авах	1,583	-32.18%
Шарын гол ХК (SHG)	Авах	2,991	-14.57%
Шивээ овоо ХК (SHV)	Авах	3,000	-11.76%
Багануур ХК (BAN)	Авах	2,200	-10.20%
Хай би ойл ХК (HBO)	Хүлээх	390	-4.88%
АПУ ХК (APU)	Хүлээх	3,680	-2.72%
Махимпекс ХК (MMX)	Авах	2,930	-1.97%
Хөх ган ХК (HGN)	Хүлээх	64	-0.31%
Говь ХК (GOV)	Авах	8,130	-0.18%
УБ-БҮК ХК (BUK)	Хүлээх	30,000	+0.00%
Ариг гал ХК (EER)	Хүлээх	2,150	+0.00%
Мерекс ХК (MRX)	Авах	70	+0.00%
Би ди сек ХК (BDS)	Хүлээх	1,601	+0.06%
Талх чихэр ХК (TCK)	Авах	16,500	+2.17%
Дархан нэхий ХК (NEH)	Авах	19,500	+2.63%
Э-Транс ложистикс ХК (ETR)	Хүлээх	115	+4.55%
Баянгол зочид буудал ХК (BNG)	Авах	48,000	+6.67%
Гермес центр ХК (HRM)	Хүлээх	139	+11.09%
Улсын их дэлгүүр ХК (UID)	Зарах	599	+12.59%
Женко тур бюро ХК (JTB)	Авах	88	+20.55%

\*Богино хугацааны санал

Эх сурвалж: МХБ

## Олон улсын индексүүд

Индекс	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт	2016.01.01-тэй харьцуулсан
DJIA (US)	-2.3%	-2.4%
Nikkei 225 (JP)	-9.23%	-11.15%
Hang Seng (HK)	-13.57%	-8.01%
DAX 30 (DE)	-15.69%	-9.35%
SMI (CH)	-9.48%	-9.85%
MSE 20	-15.71%	-10.48%

Эх сурвалж: Блумберг

## Валютын ханш

	2016.02.07	2016.03.07	Өөрчлөлт
USD - ТӨГ	2,018.53	2,045.88	+1.35%
EUR - ТӨГ	2,260.45	2,244.13	-0.72%
JPY - ТӨГ	17.29	17.99	+4.05%
CHF - ТӨГ	2,031.12	2,053.17	+1.09%

Эх сурвалж: Монголбанк


## Үнэт цаасны зах зээлийн мэдээ

### Хувьцааны арилжаа

МХБ-ээр 2016 оны 2-р сард нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, 71 компанийн 5,635,476 ширхэг хувьцаа арилжигджээ. Энэ нь өмнөх оны мөн үед хийгдсэн арилжааны дүнтэй харьцуулахад 4.1 хувь буурсан үзүүлэлт байсан бол өмнөх 1-р сарын 466.2 сая төгрөгийн арилжааны дүнтэй харьцуулахад 2.4 дахин их байна.

### ЗГҮЦ-ны арилжаа

2016 он гарсаар нийт 24.7 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсан байна. Энэ нь өнгөрсөн үеийнхтэй харьцуулахад 2.4 дахин бага дүн байв. Мөн гүйлгээнд 39 долоо хоногтой /9 сар/ богино хугацаат ЗГҮЦ нэмэгдсэн. Өгөөжийн хэмжээ 2-р сард дунджаар 14.7 хувьд хүрсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 0.7 нэгжээр буурсан үзүүлэлттэй байлаа.



### Айтүүлс ХК-ийн үнэт цаасыг МХБ бүртгэлээ (MSE:ITLS)

Айтүүлс ХК нь 2016 оны 1-р сарын 29-ний өдөр СЗХ-ны 20-р тогтоолоор үнэт цаасаа олон нийтэд гаргах зөвшөөрлийг авсан бөгөөд 2016 оны 3-р сарын 3-ны өдрийн МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 79 тоот тушаалаар тус компанийн хувьцааг ITLS гэсэн үсгэн симболоор /тоон код 543/ биржид бүртгэлээ. Айтүүлс ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан ба үндсэн үйлчилгээ нь интернэтийн технологид суурилсан дата төвийн үйлчилгээ бөгөөд түүнийг дагалдах үйлчилгээ болох домэйн нэрийн бүртгэл, и-мэйл, интернэт түгээлт зэрэг 30 гаран төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг.

Айтүүлс ХК нь нийт хувьцааны 43.8 хувийг олон нийтэд санал болгож, 1.9 тэрбум төгрөг татахаар төлөвлөж байна. Айтүүлс ХК нь олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгөөр Дархан хотод Модуляр дата төвийн парк байгуулна. Нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг нэрлэсэн үнээр буюу 1,000 төгрөгөөр тогтоосон бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг энэ 4-р сард хийхээр төвлөсөн байна. Та бүхэн ITLS үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгыг энд дарж авна уу. Мөн андеррайтер Стандарт инвестмент ҮЦК-ийн 70114433 дугаараас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

### Сүү ХК-ийн хувьцаа хуваагдах асуудал хойшлов

Сүү ХК-ийн нэгж хувьцааны үнэ сүүлийн 2 жилийн хугацаанд 150,000 төгрөгт хүрсэн ба 2013-2014 онд нийт ердөө 57 удаа арилжигджээ. Гэтэл энэ хугацаанд идэвхтэйд тооцогддог АПУ ХК-ийн хувьцаа 423 удаа, Ремикон ХК-ийнх 361 удаа арилжигдсан байна. Тиймээс Сүү ХК хувьцааныхаа арилжааг идэвхжүүлэхийн тулд 2016.01.29-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хувьцааг 1,000 хуваахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой хүсэлтийг МХБ-д хүргүүлсэн ч материал дутуу байсан тул хувьцааг хуваах явц хойшилж, дараагийн ХЭХ-ийн хурлаар дахин хэлэлцүүлж, МХБ-д дахин хандахаар болсон байна.

### АСЕМ-ийн уулзалт 7-р сарын 15-16 нд болно

2016 оны 7-р сарын 15-16 өдрүүдэд Ази-Европын уулзалт буюу АСЕМ-ийн 11 дэх удаагийн дээд түвшний уулзалт Монгол Улсад болох бөгөөд үүнд оролцохоор 2 тивийн 53 орны удирдагчид хүрэлцэн ирэхээр болжээ. Тус хуралтай холбоотойгоор дагалдах нийт 8 хурал 4-р сарын 21-ээс эхлэн УБ хотноо хуралдаж эхлэх юм. Энэхүү хурлууд зохион байгуулагдснаар Монгол Улсад хамгийн багадаа 4-5 мянган зочид төлөөлөгч ирэх ба Монголоо сурталчлах томоохон боломжийг үүсгэж байна.

## 2015 оны IV улирлын санхүүгийн тайлангийн мэдээлэл

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жил болон жилийн эцэст санхүүгийн тайланг МХБ-ээр олон нийтэд тайлагнах үүрэгтэй байдаг. Одоогийн байдлаар IV улирлын байдлаар 51 компанийн санхүүгийн тайлан олон нийтэд нээлттэй болсон байгаа ба тэдгээрийн 8 нь төрийн өмчит хувьцаат компани байна. Мөн эдгээр тайлангаа ирүүлсэн компаниудаас 22 компани нь ашигтай ажилласан ба нийт ашгийн хэмжээ 18.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин бусад алдагдалтай ажилласан компаниудын нийт алдагдлын хэмжээ 4.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Симбол	Хувьцаат компанийн нэр	Нийт хөрөнгө, мян.төг	Өр төлбөрийн нийт дүн, мян.төг	Тайланг үеийн цэвэр ашиг, мян.төг	Хувьцааны ханш, төг 2016.03.05	Дансны үнэ, төг	Үнэ эзэмшигчдийн өмчийн харьцаа	Үнэ ашгийн харьцаа
MUDX	Мүдикс	21,671	39,112	(185,870)	8,000	(211.62)	(37.80)	(3.55)
UID	Улсын их дэлгүүр	9,866,467	10,671,437	105,784	599	(21.87)	(27.39)	208.42
HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл	65,582	73,588	-	3,700	(160.11)	(23.11)	но
BNB	Баялаг налайх	54,701	63,740	(5,128)	440	(28.98)	(15.18)	(26.76)
SOI	Еврофёазиа	393,841	649,229	(298,328)	2,094	(568.23)	(3.69)	(4.27)
HHN	Хархорин	6,972,215	7,461,402	(443,358)	1,610	(906.72)	(1.78)	(1.96)
BSKY	Блоскай секьюритиз	26,401	147,797	(50,242)	2,150	(1,559.07)	(1.38)	(3.74)
BBD	Стандарт проперти групп	14,133,365	14,482,472	(239,525)	107	(214.83)	(0.50)	(0.73)
HUZ	Хөвсгөл Усан зам	91,527	1,779,961	(264,647)	371	(17,881.04)	(0.02)	(0.13)
JRG	Эвлэл	519,872	353,442	1,140	172	3,800	0.05	6.61
ADL	Адуун чулуун	10,029,103	690,683	524,762	1,137	2,963	0.38	6.83
MDR	Монголиа девелопмент ресорсес	16,353,974	113,031	85,436	455	1,120	0.41	73.23
NXE	Нэхээсгүй эдлэл	9,981,263	8,381,668	23,990	1,145	19,409	0.06	3.93
MCH	Монголын цахилгаан холбоо	38,496,383	7,724,506	(728,754)	706	1,166	0.61	(25.06)
MRX	Мерекс	7,011,582	1,260,545	191,421	70	86	0.81	23.77
GOV	Говь	122,760,787	54,285,550	10,747,883	8,130	8,777	0.93	5.90
JTB	Женкотур бюро	10,862,927	1,871,617	65,264	88	90	0.98	134.84
ATR	Атарөргөө	10,400,586	423,720	665,629	65,000	57,282	1.13	17.00
SHG	Шарынгол	71,230,651	42,446,887	(685,095)	2,991	2,812	1.06	(44.40)
MSR	Монгол шир	626,289	367,644	(18,634)	1,350	939	1.44	(19.95)
HRM	Гермес центр	8,438,822	219,611	738,389	139	76	1.84	14.77
BDS	Бидисек	15,757,001	481,961	13,934	1,601	898	1.78	1,953.27
SUU	Сүү	56,802,209	30,330,694	557,169	120,000	76,923	1.56	74.09
BTG	Баянтээг	2,904,931	907,617	348,126	14,440	7,904	1.83	10.48
HBO	Хай би ойл	9,714,513	699,529	26,764	390	173	2.26	759.46
DZG	Дархан зочид буудал	1,163,350	407,418	(42,177)	20,000	8,378	2.39	(42.42)
GTL	Гутал	8,152,149	275,590	1,964,906	15,830	4,866	3.25	13.04
SUL	Газар сүлжмэл	1,665,986	934,600	696,817	54,000	11,190	4.83	5.07
CHR	Увс чацаргана	432,561	319,710	857	933	158	5.90	776.86
UND	Ундрага өмнөговь	107,422	3,243	(21,094)	6,300	1,099	5.73	(28.31)
BHR	Бинсэ	588,673	291,128	(235,081)	780	131	5.95	(7.53)
MSC	Монгол секьюритиес	352,260	158,871	(23,949)	888	6	137.75	(1,112.3)
VIK	Баян Алдар	44,922	42,759	(44,875)	1,333	11	124.90	(6.02)

## Ногдол ашиг тараалтын мэдээлэл

2015 оны жилийн эцсийн байдлаар ашигтай ажилласан дараах хувьцаат компаниуд ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг гарган, Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцүүлэхээр болсон байна.

№	Симбол	Компаний нэр	Ногдол ашиг, төгрөг	Бүртгэлийн өдөр
1	APU	АПУ ХК	70	2016/04/14
2	AZH	Алтайн зам	Тараахгүй	2016/02/28
3	SUL	Газар сүлжмэл ХК	10,201.91	2016/03/14
4	HRM	Гермес ХК	4.39	2016/03/07
5	GOV	Говь ХК	140	2016/03/11
6	GTL	Гутал ХК	749	тодорхойгүй
7	MMX	Мах Импекс ХК	100	тодорхойгүй
8	HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл ХК	Тараахгүй	тодорхойгүй
9	SOR	Сор	Тараахгүй	2016/03/11
10	TCK	Талх чихэр ХК	130	тодорхойгүй
11	SHG	Шарын гол ХК	Тараахгүй	тодорхойгүй

Эх сурвалж: МХБ

## 2016 оны 3-р болон 4-р сард хуралдах Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов

ХЭХ хуралдах өдөр	ХК-ийн нэр	Цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хурлаар хэлэлцэх асуудал
2016.03.18	Монгол нэхмэл	16:00	УБ хот, ХУД, 2 хороо Чингисийн өргөн чөлөө Компанийн өөрийн байранд	2016/02/06	1. Компанийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах 2. ТУЗөвлөлийн тайлан, 2016 оны төсөв төлөвлөгөөг хэлэлцэж батлах 3. Бусад
2016.03.21	Дархан хөвөн	16:00	СБ, 6-р хороо багатайруу Монренгийн байрны 305 тоот	2016/02/29	1. Компанийн ажлын тайлан, компанийн дүрмийг батлах, 2. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, 3. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох, 4. ТУЗ-д их хэмжээний хэлцэл хийх эрх олгох зэрэг асуудлыг тус тус хэлэлцэнэ.
2016.03.23	Баянтээг	10:00	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, "Нутгийн удирдлагын ордон"-ны 3 давхарт 303А тоот	2016/02/28	1. Компанийн 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан, 2. Аудитын хорооны тайлан дүгнэлт, 3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны цалин урамшуулал болон зардлын төсөв, 4. Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх, 5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, 6. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх
2016.03.24	Материал импекс	10:30	"Материалимпекс" хувьцаат компанийн хурлын танхим	2016/02/16	1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх 2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, 3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах, 4. Аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулах, ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлэл сонсох
2016.03.24	Адуунчулуун	15:00	Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг Адуунчулуун ХК-ийн хурлын танхимд	2016/02/28	1. Адуунчулуун ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, 2. ТУЗ-ийн дүгнэлт, нэгж хувьцаанд олгох ногдол ашгийг хувиарлах талаар, 3. Компанийн 2016 оны төлөвлөгөө
2016.03.25	Дорнод худалдаа	14:00	Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг	2016/03/15	1. 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, 2. Ногдол ашиг хуваарилах тухай, 3. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2016-2017 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах, 4. Бусад
2016.03.26	Дархан нэхий	14:00	"Дархан нэхий" ХК-ийн байранд	2016/02/29	1. Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг хэлэлцэж дүгнэх 2. Аудитын хорооны 2015 оны ажлын тайлан, дүгнэлт 3. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн төсөв батлах 4. Ногдол ашиг хуваарилах тухай 5. Цаг үеийн болон бусад асуудал
2016.03.26	Хархорин	14:00	Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтөлгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах Компаний өөрийн байрны хурлын танхимд	2016/03/04	1. Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, 2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах, 3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, 4. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах, 5. "Хархорин үндэсний цэцэрлэг" төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, 6. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд тусгасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн гарсан хувьцааны дүнтэй зөрүүтэй байгаа асуудлыг хэлэлцэх

ХЭХ хуралдах өдөр	ХК-ийн нэр	Цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хурлаар хэлэлцэх асуудал
2016.03.30	Ганхийц	10:00	СХД-ийн 7-р хороо Ган хийц ХК-н байр	2016/03/10	1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны хийсэн ажлын тайлан, 2016 онд хийгдэх ажлын үндсэн чиглэл, 2. ТУЗ-н 2016 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2016 оны зардлын төсөв, 3.ТУЗ-н хурлаар компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтэд хийсэн дүгнэлтийг танилцуулна. 4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
2016.04.01	Хүнс Архангай	14:00	Архангай аймгийн Эрдэнэбулган сум 4-р баг Хүнсний Үйлдвэрийн байр	2016/03/10	1. Компанийн дүрмийг шинэчлэн батлах, 2. Компанийн хэлбэрийг өөрчлөх, 3. Компанийн гүйцэтгэх удирдлагад их хэмжээний хэлцэл хийх эрх олгох, 4. Үйл ажиллагааны ба санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах
2016.04.04	Техник импорт	9:00	БГД, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125. Өөрийн байр	2016/03/09	1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын Аудитын хорооноос гаргасан дүгнэлт, 2. Компанийн 2015 оны ажлын тайлан, 3. 2016 оны ажлын төлөвлөгөө, 4. ТУЗ-ын гишүүдийг сонгох, 5. Бусад
2016.04.04	Уужим-хангай	9:00	УБ хот, ЧД, 1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3	2016/03/05	1.Компанийн 2015 оны жилийн эцсийн аудитоор баталгаажсан тайланг хэлэлцэх; 2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох; 3. Ногдол ашиг хуваарилахгүй талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, 4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай 5.Компани нэгтгэн өөрчлөн байгуулах явц 6. Бусад асуудлаар;
2016.04.04	Увс хүнс	10:00	Увс аймаг, Улаангом сум, 5-р баг, "Увс Хүнс" ХК-н байр	2016/03/10	1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, 2. Компанийн санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт 3. Компанийн хянан шалгах зөвлөлийн тайлан 4. Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө 5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах 6. Компанийн тухай хуулийн 94,3-т заасан дагуу сонгосон аудитын байгууллагатай хийх гэрээг батлах
2016.04.04	Алтайн-зам	16:00	СХД 4-р хороо, Алтан тариа үйлдвэрийн баруун талд өөрийн байр	2016/02/28	1. 2015 оны санхүүгийн тайлан 2. 2015 оны үйл ажиллагааны тайлан 3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт 4. 2015 оны ТУЗ-ийн тогтоолууд 5. 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 6. Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв 7. ТУЗ-ийн зардлын төсөв 8. Ногдол ашиг тараах эсэх тухай 9. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга 10. 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоол
2016.04.07	Мон-Ит булгаар	10:00	ХУД 2 хороо АШҮ хашаа	2016/03/10	1.Компаний 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар
2016.04.08	Хөвсгөл	9:00	Хөвсгөл аймаг Мөрөн сум 8-р баг Далай ван коллежийн хурлын зааланд	2016/03/04	1.Хурлаар хэлэлцэх асуудлууд: 2. Компанийн санхүүгийн тайлан 3. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан 4.Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө батлах 5. Хянан шалгах зөвлөлийн тайлан 6.Хувьцаат компанийн дүрмийн шинэчилсэн найруулга 7. Компанийн ТУЗ-ийг сонгох 8.ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв 9. Ногдол ашиг тараах эсэх
2016.04.08	Атар-Өргөө	10:00	ХУД Чингисийн өргөн чөлөө-20 Атар-Өргөө хувьцаат компани	2016/03/07	1. Компанийн үйл ажиллагааны 2015 оны ажлын тайлан цаашдын зорилт, 2. Санхүүгийн тайлан тэнцэл, ашиг хуваарилалтын талаарх мэдээлэл, 3. ТУЗ-ийн аудитын хорооны тайлан, дүгнэлт, 4. Зохион байгуулалтын асуудал, 5. 2015 оны үйл ажиллагааны ашгаас "Ногдол ашиг хуваарилах тухай" ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах, 6. Компанийн удирдлагын болон үйл ажиллагааны 2016 оны зардлын төсөв батлах
2016.04.08	Дорнод авто зам	14:00	УБ хот, СБ, 8-р хороо, Өөрийн байр	2016/02/29	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлт 3. Компанийн аудитын хорооны тайлан 4. 2016 оны ажлын төлөвлөгөөг батлах 5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох 6. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах 7. Ногдол ашиг тараах эсэх 8. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
2016.04.08	Хөвсгөл геологи	14:00	Хөвсгөл аймаг Мөрөн сум 8-р баг "Хөвсгөл Геологи"ХК-ийн өөрийн хурлын зааланд	2016/03/04	1.Хурлаар хэлэлцэх асуудлууд: 2. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт 3.Компанийн 2015 бизнес үйл ажиллагааны тайлан 4. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг батлах 5.Хувьцаат компанийн дүрмийн шинэчилсэн найруулга 6.ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв 7.Ногдол ашиг тараах эсэх 8. Компанийн ТУЗ-ийг сонгох 9.Хөвсгөл Геологи ХК-ийн 9.2 %-ийн хувьцаа эзэмшигч Р.Лхагвадоржтой 2008 оны 04-р сарын 28-ны өдөр хийсэн тохиролцоог хэлэлцэж шийдвэр гаргах
2016.04.08	Стандарт проперти групп	15:00	БГД, 4-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, UB platinum 606	2016/03/05	1.Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх; 2.2016 оны төлөвлөгөөг танилцуулах; 3.ТУЗ-ийн гишүүдийг сонгох;4. Ногдол ашиг хуваарилахгүй талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах; 5. Бусад асуудлаар

ХЭХ хуралдах өдөр	ХК-ийн нэр	Цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хурлаар хэлэлцэх асуудал
2016.04.08	Хөвсгөл хүнс	17:00	Хөвсгөл аймаг Мөрөн сум 8-р баг Далай ван коллежийн хурлын зааланд	2016/03/04	1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах 2. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт 3. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан 4. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө 5. Хянан шалгах зөвлөлийн тайлан 6. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв 7. Компанийн ТУЗ-ийг сонгох 8. Ногдол ашиг тараах эсэх
2016.04.08	Говь	14:00	“Говь” ХК-ийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторан	2016/03/11	1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанид шинээр нэвтрүүлээд байгаа Амёб менежментийн явц, үр дүнг танилцуулах 3. 2014 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2015 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах 4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах 5. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах 1. ТУЗ-ийн тайлан, 2. Компанийн 2015 оны үйл ажиллаганы үр дүнгийн тайлан, 3. 2016 оны үйл ажиллаганы чиглэл, 4. 2015 оны санхүүгийн тайлан, 5. Хөндлөнгийн Аудитын дүгнэлт, 6. Бусад асуудал
2016.04.09	Барилга корпораци	10:00	УБ -11, Барилгачдын талбай-13, Засгийн Газрын 12-р байрны Зүүн Хойд Өргөгдөлийн 4А-1	2016/03/07	1. ТУЗ-ийн тайлан, 2. Компанийн 2015 оны үйл ажиллаганы үр дүнгийн тайлан, 3. 2016 оны үйл ажиллаганы чиглэл, 4. 2015 оны санхүүгийн тайлан, 5. Хөндлөнгийн Аудитын дүгнэлт, 6. Бусад асуудал
2016.04.11	Багануур	10:00	БЗД, 18-р хороо, , “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн газар	2016/03/11	1. Нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх, 2. Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны үнэд хуулинд заасан хэмжээнд хөнгөлөлт эдлүүлэх эсэх, 1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах 2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, 3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, 4. Бусад
2016.04.11	Хүрд	16:00	УБ, ЧД 6-р хороо, Сүхбаатарын гудамж-71, Хүрд компанийн байр	2016/02/15	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв 6. Бусад
2016.04.15	Монгол савхи	10:00	Монгол савхи ХК-ийн байранд	2016/03/08	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв 6. Бусад
2016.04.15	Жуулчин говь	13:00	Монгол савхи ХК-ийн байранд	2016/03/08	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв
2016.04.15	Тулпар	15:00	ТУЛПААР ХК-ны байранд, сургалтын танхимд	2016/03/03	1. 2015 оны компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт, 2. 2015 оны компанийн үйл ажиллагааны тайлан 3. компанийг өөрчлөн байгуулах төсөл, 4. ТУЗ-ын гишүүдийн бүрэлдэхүүн сонгох, 5. 2016 оны зорилт, бусад асуудал
2016.04.15	Мандал-говь импекс	15:00	ХУД, 2-р хороо	2016/03/10	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, 2. Компанийн ТУЗ-ийн тайлан, 3. Аудитын хорооны тайлан, 4. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв
2016.04.15	Оллоо	17:00	СБД, 1-р хороо, Чагдаржавын гудамж, 42-4 тоот	2016/03/04	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт 2. Компанийн 2016 оны ажлын төлөвлөгөө 3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчлөн томилох асуудал
2016.04.20	Гермес центр	15:00	УБ хот, БГД, 4-р хороо, Нарны зам-20, Гермес центр ХК-ны төв оффисын байрны 3 давхар 302 тоот	2016/03/07	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан 2. Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт 3. Компанийн 2014 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2015 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2016 оны ногдол ашгийн тухай 4. Компанийн ТУЗ-н болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай 5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай 6. Компанийн 2016 оны үйл ажиллагааны зорилтын тухай 7. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
2016.04.22	Зоос гоёл	11:00	УБ хот, ЧД, 4-р хороо, Ж. Самбуугийн гудамж-22 "Зоос Гоёл" ХК-ийн байранд	2016/03/12	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон хувьцаа нэгтгэх төслийн хэрэгжилтийн үр дүнгийн тухай, 2. Компанийн 2015 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн /Аудитын хорооны/ дүгнэлтийн тухай, 3. 2015 оны цэвэр ашгаас ногдол ашиг хувиарлах тухай, 4. ТУЗ-ийн 2015-2016 оны зардлын гүйцэтгэл, 2016-2017 оны зардлын төсвийг батлах тухай. 5. Бусад асуудал
2016.04.22	АПУ	15:00	УБ хот, ХУД-ийн Соёлын ордон	2016/03/14	1. АПУ ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах; 2. АПУ ХК-ийн энгийн 1 (нэг) ширхэг хувьцааг тухайн төрлийн 10 (арав) ширхэг хувьцаанд хөрвүүлэх замаар хуваах асуудлыг хэлэлцэж батлах; 3. АПУ ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах.
2016.04.25	Ган хэрлэн	15:00	Дорнод аймаг Чойбалсан хот өөрийн байр	2016/03/10	1. Ган Хэрлэн ХК-ийн 2015 оны санхүүгийн тайлан 2. Ган Хэрлэн ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 3. Бусад

ХЭХ хуралдах өдөр	ХК-ийн нэр	Цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хурлаар хэлэлцэх асуудал
2016.04.25	Монинж-бар	16:00	ЧД, 6-р хороо, Бага тойруу 24/3 өөрийн байранд	2016/03/19	1.2015 оны үйл ажиллагааны тайлан 2.2015 оны санхүүгийн тайлан 3.2016 оны зорилго 4.Ногдол ашгийн тухай
2016.04.26	Сэлэнгэ сүрлэг	10:00	Сэлэнгэ аймаг, орхонтуул сум	2016/03/10	1.2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүн цаашдын зорилт 2.2015 оны санхүүгийн тайлан тэнцлийн тухай 3.2015 оны жилийн эцсийн тайланд хийсэн аудитын дүгнэлт 4.компанийн дүрмийн 8.10-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай
2016.04.28	Тахь-ко	10:00	ЧД, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18 өөрийн байр, Анкор төвийн хурлын зааланд	2016/03/14	1. Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт. 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох. 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
2016.04.28	Могойн гол	11:00	Хөвсгөл аймаг Мөрөн сум 8-р баг, Удирдлагын ордон, А-байр 3-н давхар Иргэний танхим	2016/02/29	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт 2. 2016 оны ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай 3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох 4. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг мэдээлж батлах тухай 5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах туха
2016.04.29	Машин механизм	11:00	УБ хот, БГД 1-р хороо компанийн байр	2016/03/14	1.Компанийн дүрэм 2.Компанийн үйл ажиллагааны тайлан батлах 3.Компанийн ТУЗ-ийн хараат бус болон ердийн гишүүнийг сонгох 4.2016 оны үйл ажиллагааны төсөв батлах 5.ТУЗ-ийн ногдол ашгийн тухай тогтоол батлах
2016.04.29	Таван-толгой	14:00	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Тавантолгой" ХК-ийн хурлын танхим.	2016/03/10	1.Компаний 2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, 2.Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, 3.2014 оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2015 оны ногдол ашиг хуваарилах тухай, 4.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны төсвийг батлах тухай, 5.Бусад
2016.04.29	Бөхөг	10:00	ХУД, 13-р хороо, Туул тосгон, өөрийн байр	2016/03/14	1. Компанийн 2014-2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, 2. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах, 3. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх, 4. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах, 5. Бусад
2016.04.29	Сор	10:00	УБ хот, ХУД, 2-р хороо, чингисийн өргөн чөлөө, Сор ХК өөрийн байр	2016/03/11	1.Сор ХК-ийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах. 2.Сор ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. 3.ТУЗ-ийн гишүүд сонгох.
2016.04.29	УБ хивс	11:00	ХУД, УБ хивс ХК-ийн байр.	2016/03/14	1. УБ хивс ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны үр дүн, 2016 оны үндсэн зорилт, үзүүдэлтийн тухай, 2. УБ хивс ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, 3. УБ хивс ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн ээлжит сонгууль, 4. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2016 оны зардлын төсөв батлах тухай

Эх сурвалж: МХБ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [chimgee@standardinvestment.mn](mailto:chimgee@standardinvestment.mn) цахим хаягаар холбогдоно уу.

## **Холбоо барих хаяг**

Стандарт Инвестмент ҮЦК  
УБ хот, ЧД  
1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3

## **Шуудангийн хаяг:**

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487  
УБ - 15160  
Утас: 70114433  
info@standardinvestment.mn  
www.standardinvestment.mn

## **Тодруулга болон мэдэгдэл**

Энэхүү тойм мэдээг Стандарт Инвестмент ҮЦК /Үнэт цаасны компани/ бэлтгэсэн болно. Тойм мэдээнд дурьдагдсан хувьцаат компаниуд болон тэдгээрийн хувьцааны талаарх мэдээлэл, дүгнэлтийг үнэн зөвөөр гаргахыг хичээсэн бөгөөд Стандарт Инвестмент ҮЦК-ийн шинжээчдийн өөрсдийн үзэл бодол болно.

Стандарт Инвестмент ҮЦК нь Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага юм. Бид иргэд, байгуулагуудад үнэт цаас худалдах, худалдан авахад нь зуучлах, өөрийн нэр дээр үнэт цаас худалдан авах, худалдах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон үйлчилгээ үзүүлэх, андеррайтер болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлдэг.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭ НЬ ЯМАР НЭГЭН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ САНАЛ БИШ ЮМ. ЭНД ДУРДСАН ҮНЭ ХАНШИЙН МЭДЭЭ, БУСАД ТООН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛБАР ЗЭРЭГ НЬ ЗӨВХӨН ТУХАЙН МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭХ ҮЕИЙН БАЙДЛЫГ ИЛТГЭХ БӨГӨӨД ӨӨРЧЛӨГДӨЖ, ХУВЬСАЖ БОЛНО /СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ АЛБАГҮЙ/. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ЭРСДЛИЙГ ӨӨРӨӨ ХАРИУЦНА.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭНИЙ БҮХ МЭДЭЭЛЛИЙГ ЗӨВХӨН МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗОРИЛГООР БЭЛДСЭН БӨГӨӨД НАЙДВАРТАЙ, САЙН САНААНЫ ҮҮДНЭЭС ГАРГАСАН ГЭЖ ҮЗСЭН ЭХ СУРВАЛЖААС АВЧ БОЛОВСРУУЛСАН ХЭДИЙ Ч МЭДЭЭЛЭЛ ТУС БҮРИЙГ НЭГБҮРЧЛЭН ХЯНАЖ ШАЛГААГҮЙ БОЛНО. ТИЙМЭЭС СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК НЬ ЭДГЭЭР МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БОДИТ БӨГӨӨД БҮРЭН БҮТЭН БАЙДАЛД БАТАЛГАА ГАРГАХГҮЙ БӨГӨӨД МЭДЭЭЛЛИЙГ ДАМЖУУЛАХААС ҮҮССЭН АЛИВАА АЛДААГ ХАРИУЦАХГҮЙ. ТҮҮНЧЛЭН, ЭНЭХҮҮ ТАЙЛАНГ АШИГЛАСНААС УЧИРСАН АЛИВАА ХОХИРОЛД СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ЯМАР НЭГЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ.

ЭНЭХҮҮ ТОЙМ БОЛОН СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК-ИЙН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР НЭГЭН ХЭЛБЭРЭЭР ЦААШ НЬ ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ, ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО.

©2016 *Стандарт Инвестмент ҮЦК*